

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН СОНГОН**ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**


Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 64 дүгээр тушаалаар "Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн 19 сул орон тоонд сонгон шалгаруулалт" зарлалаа. Үүнд:

№	Шүүхийн нэр, албан тушаал	Орон тоо
Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тоо		
1	Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын шүүгч	1
Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сул орон тоо		
2	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоо		
3	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	1
Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сул орон тоо		
4	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
5	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
6	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
7	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
8	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
9	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
10	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
11	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
12	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
13	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
14	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
15	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	1
16	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	1
Анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоо		
17	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
18	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
19	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
Нийт		19

НЭГ. Нэр дэвшигчид тавигдах болзол шаардлага:


I. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧ:

Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан дараах болзол, шаардлагыг хангасан байна. Үүнд:




II. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧ:

Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшигч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.1, 7.1.4 дэх хэсэгт заасны дагуу анхан шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангасан байхаас гадна **дараах шаардлагыг хангасан** байна. Үүнд:




III. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧ:

Давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтад заасны дагуу анхан шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангасан байхаас гадна **дараах шаардлагыг хангасан** байна. Үүнд:




IV. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧ:

Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшигч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.2, 7.1.4 дэхь заалтад заасны дагуу давж заалдах шатны шүүхийн шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангасан байхаас гадна **дараах шаардлагыг хангасан** байна. Үүнд:




V. ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧ:


Хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангахаас гадна **дараах шаардлагыг хангасан** байна. Үүнд:



ХОЁР. Бүртгэлийн хугацаа



ГУРАВ. Бүртгүүлэх хэлбэр



БҮРДҮҮЛЭХ БАРИМТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.


Д/д	Баримт материал	Холбогдолтой хэсэг
1.	Төрийн албан хаагчийн анкет	Энд дарж татаж авна уу.
2.	Өргөдөл	<p>Өргөдлийн агуулгад дараах мэдээллийг заавал тусгаж өгсөн байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хэдэн оны хэддүгээр тушаалаар зарласан аль шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлэх хүсэлтэй байгаа тухайгаа; 2. Бусдад хугацаа хэтэрсэн өр зээлгүй эсэхээ; 3. Шүүгчийн сонгон шалгаруулалтад бүртгэгдсэн тохиолдолд хувь хүний мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлэхийг зөвшөөрч буй эсэхээ; 4. Хуульчийн гэрчилгээ авсан огноо, хуульчийн гэрчилгээний дугаараа заавал тусгасан байна. <p>Нөөцөөс нэр дэвшигч өргөдөлдөө дээрх заавал тусгах мэдээлэл дээр нэмж;</p> <ol style="list-style-type: none"> 6. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хэдэн оны хэддүгээр тушаалаар зарласан, аль шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцсон; 7. Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээнд авсан оноогоо тусгана.
3.	Гурван үеийн намтар	Өөрийн, эцгийн, өвөг эцгийн намтрыг бичиж, хуудас бүрт гарын үсэг зурсан байна. Гурван үеийн намтраа www.shuugch-songon.mn цахим хуудсанд оруулахдаа хавсралтын төрлөө "Нэр дэвшигчийн мэдээллийн хүснэгт" гэж сонгож оруулна уу.
4.	Монгол Улсын иргэний үнэмлэхний хуулбар	Нотариатаар гэрчлүүлсэн байх.
5.	Цээж зураг	Хэрвээ Та шүүгч, Ерөнхий шүүгчээр томилогдсон тохиолдолд шүүгчийн үнэмлэх дээр наах тул сүүлийн нэг сарын дотор авахуулсан , албан хувцаслалттай /аливаа дүрэмт хувцастай байж болохгүй/, 3x4 хэмжээтэй, 2 ширхэг байх;
6.	Бүрэн дунд боловсролын гэрчилгээ	Хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд тухайн сургуулийг төгссөн талаар холбогдох байгууллагын тодорхойлолтыг хавсаргах.
7.	Их, дээд сургууль төгссөн диплом	Хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд тухайн сургуулийг төгссөн талаар холбогдох байгууллагын тодорхойлолтыг хавсаргах, Гадаад улсын их, дээд сургуулийн дипломыг тухайн улсын Элчин сайдын яамнаас баталгаажуулсан тодорхойлолт авсан байх, дипломын орчуулгын хамт ирүүлэх.
8.	Оршин суугаа газрын тодорхойлолт	ТҮЦ машинаас авах.
9.	Ам бүлийн тодорхойлолт	Баг, хорооны Засаг даргаас авах.
10.	Нийгмийн даатгалын дэвтэр болон хөдөлмөр эрхэлснийг нотлох бусад баримт бичиг	Тэдгээрийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх /Ажилласан жилийг нийгмийн даатгалын дэвтрийн Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бичилт болон "Ажилд орсон, шилжсэн, чөлөөлсөн" гэсэн бичилтийг үндэслэн тооцно/.
11.	Эрүүл мэндийн үзлэгийн маягт	Эрүүл мэндийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2014 оны 41/20 тоот албан тушаалын хоёрдугаар хавсралт (Маягтыг Энд дарж татаж авна уу)-ын дагуу бөглөнө/, /Шүүгчээр ажиллаж байгаа хуульчид хамаарахгүй/.
12.	Эд хөрөнгөө тодорхойлж бичсэн жагсаалт (ХОМ)	УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт (Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг)-ын дагуу бөглөнө (Маягтыг Энд дарж татаж авна уу)/, /Шүүгчээр ажиллаж байгаа хуульчид хамаарахгүй/.

13.	Мэргэшсэн чиглэлээр мэргэжлийн хэвлэлд өгүүлэл бичин, нийтлүүлсэн бол хэвлэгдсэн ном, сэтгүүлийн эх сурвалжийн мэдээлэл	Зөвхөн давж заалдах шатны шүүхийн шүүгч болон Ерөнхий шүүгчид нэр дэвшигчид хамаарна. /мэдээлэлд: өгүүлэл, нийтлэлийн нэр, хэвлэгдсэн огноо, хэвлэлийн нэрийг тусгасан байна/.
14.	Ажил байдлын тодорхойлолт	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.8-д заасны дагуу хөдөлмөр эрхэлж байгаа бол эрхэлсэн ажлын байдал, хамт олны доторх нэр хүнд, зан төлөвийн тухай аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тодорхойлолтыг ирүүлэх.
15.	Хуульчийн гэрчилгээний хуулбар	Нотариатаар гэрчлүүлсэн байх.

ТАВ. Анхаарах зүйл:



Баримтыг дутуу бүрдүүлсэн тохиолдолд бүртгэлээс хасах үндэслэл болохыг анхаарна уу! Баримт материалыг бүрдэл тус бүрээр .pdf файл болгон програмд оруулах (жишээ нь: нийгмийн даатгалын дэвтрийг нүүр, бичилт хийгдсэн бүх хуудсуудтай нь нэгтгэж нэг .pdf файл болгох)



Бүртгүүлэх материалын аль нэг бүрдлийн хуудас дутуу орсон тохиолдолд баримтыг дутуу бүрдүүлсэнд тооцох тул оруулсан файл тус бүрээ бүрэн гүйцэт эсэхийг нягтлан шалгана уу.



Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг Хяналтын шатны шүүхийн шүүгчээр томилохыг хориглодог болно.

Тодруулах мэдээллийг ажлын өдрүүдэд 08:30-12:30, 13:30-17:30 цагийн хооронд 7000-8022 утсанд холбогдож авна уу.